

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ БОЛОН
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТЭЭВРИЙН ЯАМ ХООРОНДЫН
ПРОТОКОЛ**

Монгол Улсын Зам, тээврийн яам болон Оросын Холбооны Улсын Тээврийн яам (цаашид “Талууд” гэх),

Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хоёр талт хамтын ажиллагааг харилцан ашигтай, түншлэлийн зарчим дээр үндэслэн бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх харилцан эрмэлзлийг удирдлага болгож,

агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг цаашид идэвхжүүлэхэд чиглэсэн өөрсдийн хүсэл тэмүүллийг батлан илэрхийлж,

тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдлыг онцлон тэмдэглэж,

Монгол Улс болон Оросын Холбооны Улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай гэрээг хэрэгжүүлэхэд болон иргэний нисэхийг хөгжүүлэх талаар цаашдын хамтын ажиллагааны чиглэл, хэлбэрийг тодорхойлоход өөрийн эрх хэмжээний хүрээнд оролцохыг эрмэлзэж,

дараахь зүйлийн талаар харилцан ойлголцолд хүрэв:

1. Талууд өөрийн улсын хууль тогтоомжид нийцүүлэн харилцан сонирхсон бүхий л чиглэлээр агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэхэд хүчин чармайлт гаргана.

2. Талууд дараахь чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэнэ:

2.1. Монгол Улсын иргэний нисэхийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг Оросын Холбооны Улсын иргэний нисэхийн боловсролын байгууллагад нөхөн төлөх (төлбөртэйгөөр) үндсэн дээр (нислэгийн, нислэгийн удирдагч, инженер техникийн ажилтан ба бусад) бэлтгэх, сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх;

2.2. Нисэхийн эрэн хайх, авран туслах чиглэлд уялдаа холбоог хөгжүүлж, боловсронгуй болгох;

2.3. Монгол Улс агаарын хөлөг хоорондын босоо зайчлалын системд 2015 оноос шилжихээр төлөвлөж байгаатай холбогдуулан 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо байгуулагдсан Олон улсын иргэний

нисэхийн конвенцийн 2 дугаар хавсралтын 3 дугаар нэмэлтийн а) хүснэгтийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт агаарын хөлөг хоорондын зайчлалын дээрх системийг нэвтрүүлэх болон ашиглах;

2.4. Монгол Улсад ашиглагдаж буй ЗХУ болон ОХУ-д үйлдвэрлэсэн агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварыг хадгалах асуудлаар хамтран ажиллах.

3. Талууд энэхүү хамтын ажиллагааны тухай протоколын заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарч буй асуудлыг хэлэлцэж байх зорилгоор шинжээчдийн түвшинд ажлын уулзалтын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлж байна.

4. Энэхүү хамтын ажиллагааны тухай протокол нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Улаанбаатар хотноо 2014 оны 9 дүгээр сарын ...-ны өдөр монгол, орос хэлээр хоёр эх хувь үйлдэв.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ**



А. ГАНСҮХ

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ТЭЭВРИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ**



М.Ю.СОКОЛОВ

**ПРОТОКОЛ О НАМЕРЕНИЯХ
В СФЕРЕ ГРАЖДАНСКОЙ АВИАЦИИ МЕЖДУ МИНИСТЕРСТВОМ
ДОРОГ И ТРАНСПОРТА МОНГОЛИИ И МИНИСТЕРСТВОМ
ТРАНСПОРТА РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ**

Министерство дорог и транспорта Монголии и Министерство транспорта Российской Федерации, именуемые в дальнейшем Сторонами,

руководствуясь взаимным стремлением содействовать налаживанию

и укреплению двустороннего сотрудничества Монголии и Российской Федерации на основе принципов партнерства и взаимности,

подтверждая свое стремление к дальнейшей активизации сотрудничества в области воздушного транспорта,

отмечая важность расширения сотрудничества в области реализации проектов развития транспортной инфраструктуры,

желая, в рамках своей компетенции, принять участие в реализации договоренностей о развитии сотрудничества между Монголией

и Российской Федерацией и определении направлений и форм дальнейшего сотрудничества в сфере развития гражданской авиации,

пришли к взаимопониманию о нижеследующем:

1. Стороны в соответствии с законодательством своих государств приложат усилия для активизации и расширения сотрудничества в сфере воздушного транспорта по всем направлениям, представляющим взаимный интерес.

2. Стороны намерены развивать сотрудничество по следующим направлениям:

2.1. Обучение, подготовка, переподготовка и повышение квалификации специалистов для гражданской авиации Монголии (летный, диспетчерский, инженерно-технический состав и др.) в учебных заведениях гражданской авиации Российской Федерации на возмездной основе;

2.2. Развитие и совершенствование взаимодействия в области авиационного поиска и спасания;

2.3. Внедрение и использование на территории Монголии системы

вертикального эшелонирования воздушных судов, соответствующей Таблице а) Добавления 3 Приложения 2 к Конвенции о международной гражданской авиации, заключенной в г. Чикаго, от 7 декабря 1944 года, в связи с планируемым переходом Монгольской Стороны с 2015 года на указанную систему эшелонирования воздушных судов;

2.4. Взаимодействие по вопросам поддержания летной годности воздушных судов советского и российского производства, эксплуатируемых в Монголии.

3. Стороны выражают заинтересованность в продолжении двустороннего сотрудничества в рамках рабочих встреч на экспертном уровне с целью обсуждения практических вопросов, связанных с реализацией положений настоящего Протокола о намерениях.

4. Настоящий Протокол о намерениях применяется с момента его подписания.

Подписано в г. Улан-Батор « » сентября 2014 года в двух экземплярах на монгольском и русском языках.

**МИНИСТР ДОРОГ И ТРАНСПОРТА
МОНГОЛИИ**



А.ГАНСУХ

**МИНИСТР ТРАНСПОРТА
РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ**



М.Ю.СОКОЛОВ